



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/402

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 30 дугаар тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Дуудлага худалдаа зохион байгуулах тухай” А/371 дүгээр захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуудлага худалдаа зохион байгуулах тухай А/371 дүгээр захирамжийн дагуу 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч: Ц.Хашхүү (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Э.Хорлоо (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г. Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

2. Дуудлага худалдааг хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Ц.Хашхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100857

D:My Doc. Zahiramj. Zasag darga